



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



# ТҮҮХ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....

### САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу балын харандаагаар будаарай.

1. VIII Богд Жавзандамба хутагт ламыг Монгол улсын хаан ширээнд хэзээ өргөмжилсөн бэ?

- A. 1911 оны 12 сарын 29  
B. 1912 оны 7 сард  
C. 1921 оны 7 сарын 10  
D. 1914 оны 2 сарын 14

2. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалыг манлайлан тэмцсэн түүхэн зүтгэлтэн хэн бэ?

- A. Д.Сүхбаатар      B. М.Ханддорж      C. Д.Бодоо      D. Х.Чойбалсан

3. Доорх зурагт буй Богд хааны Засгийн газрын гишүүдээс Гадаад хэргийн яамны сайд М.Ханддорж аль нь вэ?



4. БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн агуулгад аль нь хамаарах вэ?

- A. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилт дэвшүүлсэн  
B. Монгол улсад улсын, хувийн, хоршооны өмчийн хэлбэрүүдийг зөвшөөрсөн  
C. МАХН бол төр нийгмийн удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин болохыг заасан  
D. Монгол улсын иргэд угсаа, шашин, эрэгтэй эмэгтэй ялгаваргүй тэгш эрхтэйг тунхагласан


5. Улс орноо хөгжүүлэхэд “Үндэсний ардчилсан” чиг шугам баримталж байсан улс төрийн зүтгэлтнүүдийг хэрхэн нэрлэж байсан бэ?

- A. Шашныхан      B. Зүүнтэн      C. Баруунтан      D. Большевикууд

6. 1932 оны зун эхэлсэн эдийн засаг, аж ахуй, соёлын салбарт богинохон хугацаанд томоохон ахиц дэвшил авчирсан бодлогыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Шинэ засгийн бодлого  
B. Шинэ эргэлтийн бодлого  
C. Шинэ сэргэлтийн бодлого  
D. Шинэ зууны бодлого

7. Дараах баримтыг анхааралтай уншаад асуултад хариулна уу.  
“Монгол Улсыг үүнээс хойш Бүрэн эрхтэй ард улс гэж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн улсын аливаа хэргийг УИХ ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газар гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүслэн дагавал зохино” гэсэн баримтын юуг илэрхийлж байна вэ?
- A. Төрийн дээд эрхийг ард түмэн эдлэх болсон тухай өгүүлжээ.  
B. Монгол Улс бүгд найрамдах засаглалтай болсон тухай өгүүлжээ.  
C. Төрийн дээд эрхийг УИХ барих болсон тухай өгүүлжээ.  
D. Засгийн газрыг УИХ-аас сонгодог тухай өгүүлжээ.
8. Монгол улс хэдэн онд НҮБ-ийн бүрэн эрхт гишүүн улс болсон бэ?
- A. 1961                      B. 1949                      C. 1945                      D. 1971
9. 1941 оноос кирилл үсэгт шилжих шийдвэр гарч, анхны түр дүрэм нь ямар нэртэйгээр нийтлэгдсэн бэ?
- A. Шинэ үсгээр үг холбох тухай  
B. Бүх орон даяар соёлын довтолгоон явуулах  
C. Шинэ эргэлтийн бодлогийг хэрэгжүүлэе  
D. Зөвлөлт ах дүүс мандтугай
10. 1924-1961 оны БНМАУ-ын боловсролын зорилго аль нь вэ?
- A. Боловсролын системийг боловсронгуй болгож сургууль, амьдралын холбоог бэхжүүлэх  
B. Сургуулийн насны хүүхдийг бүрэн дунд боловсролтой болгох  
C. Сургалтыг үйлдвэрлэлтэй холбох үндсэн дээр сургуулийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх  
D. Боловсролын тогтолцооны эх суурийг тавих
11. Цэгийн оронд тохирох нэрийг нөхөж бичээрэй.  
1961 онд ШУА-ийг байгуулахад Хэл зохиол, ....., Хөдөө аж ахуй, Анагаах ухаан, Байгалийн ухааны хүрээлэнтэйгээр байгуулжээ.
- A. Философи                      B. Социологи                      C. Хууль                      D. Түүх
12. Доорх зургаас 1940-өөд оноос эхэлж хэрэглэж эхэлсэн төрийн сүлд, далбаа аль нь вэ?





13. Монголд ажиллаж байсан Зөвлөлтийн эмч Петр Николаевич Шастины гавьяа зүтгэлийг үнэлэн Улаанбаатар хотод ямар эмнэлгийг түүний нэрэмжит болгосон бэ?

- A. 1-р эмнэлэг  
B. 2-р эмнэлэг  
C. 3-р эмнэлэг  
D. Эх нялхсын эрүүл мэндийн төв

14. Монгол улсаас Олимпын наадмын анхны медалийг ямар спортын төрлөөр авсан бэ?

- A. Жүдо  
B. Чөлөөт бөх  
C. Бокс  
D. Сур харваа

15. Дэлхийн I дайн хэдэн онд дууссан бэ?

- A. 1914 онд  
B. 1916 онд  
C. 1918 онд  
D. 1920 онд

16. Дэлхийн II дайны үед улс орнууд хоёр том хүчинд хуваагдсан байв. Доорх улсуудаас тэнхлэгийн улсуудын бүрэлдэхүүнд байсан улс аль нь вэ?

- A. Их Британ  
B. Франц  
C. ЗХУ  
D. Герман

17. Хүйтэн дайны үеийн “Умард Атлантын Эвсэл” буюу НАТО-гийн гишүүн орон аль нь вэ?


- A. Польш  
B. Унгар  
C. Болгар  
D. Итали

18. Коминтерний эсрэг гэрээнд Итали улс хэзээ нэгдэж орсон бэ?

- A. 1940 оны 9 сарын 27  
B. 1937 оны 11 сарын 6  
C. 1936 оны 11 сард  
D. 1936 оны 10 сарын 25

19. Доорх газрын зургийг ашиглан зөв хариултыг сонгоно уу.

Дэлхийн 2-р дайнд Герман улс ялагдаж, холбоотнууд Германы газар нутгийг 4 бүсэд хуваажээ. Их Британи улсын мэдлийн бүс нутаг аль нь вэ?



- A. 1  
B. 2  
C. 3  
D. 4



20. 1937-1940 онд Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт гүнзгийрч, нийтийг хамрахад гол нөлөө үзүүлсэн улс аль вэ?
- A. ДИУ                      B. ЗХУ                      C. Япон улс                      D. Герман улс
21. 1930-аад онд 40 гаруй мянган монголчууд нутгаа орхин нүүжээ. Ийнхүү дүрвэх болсны шалтгаан юу вэ?
- A. Баруунтны алдаатай бодлого                      B. Зүүнтний алдаатай бодлого  
C. Дундад Иргэн Улсын суртал ухуулга                      D. Олон жил үргэлжилсэн ган зуд
22. 1932 оны зэвсэгт бослогын түүхэн сургамж юу вэ?
- A. Хууль эрх зүйн сул орчин зэвсэгт бослого гарах боломж олгодгийг сануулдаг.  
B. Нийгэмд баян хоосны ялгааг гүнзгийрүүлж болохгүйг сануулдаг.  
C. Чинээлэг аж ахуйтнууд зөвхөн хувийн эрх ашгаа эрхэмлэдгийг сануулдаг.  
D. Төр засгийн алдаатай бослогын улмаас зэвсэгт бослого гарч болохыг сануулдаг.
23. 1930-аад онд Монголд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршиг юу вэ?
- A. Япон улс шалтаг болгон Монголын хилд халдах болсон  
B. БНМАУ, ЗХУ-ын харилцаа суларсан  
C. ЗХУ, эдийн засгийн тусламж үзүүлэхээ зогсоосон  
D. Олон хүн амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирсон
24. 1989 оны 12-р сарын 10-ны өдөр Залуучуудын соёлын ордны талбайд болсон цуглаан дээр улс төрийн ямар хүчин байгуулагдсаныг зарласан бэ?
- A. Шинэ үе бүлгэм  
B. Монголын Ардчилсан нам  
C. Монголын Ардчилсан Холбоо  
D. Шинэ Дэвшилтэт Холбоо
25. 1991 оноос үндэсний соёл, боловсролыг сэргээн хөгжүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй бодлого аль вэ?
- A. Төр ёсны уламжлалт хоёр ёсыг сэргээв.  
B. Монголын нууц товчоо зохиогдсоны 750 жилийн ойг тэмдэглэв.  
C. Үндэсний бичиг үсэгт суралцах ажлыг эхлүүлэв.  
D. Бүх ард түмний спартакиадыг зохион байгуулах болов.

